9.2. Анги бүлгийн мэдээлэл засах

Анги бүлгийн бүртгэл засах

Энэхүү үйлдлийг цэцэрлэгийн бүлгийн мэдээллийг засварлахад ашиглана. Анги бүлгийн мэдээллийг засах үйлдлийг хийхэд дараах дарааллыг баримтлана. Үүнд:

Анги бүлэг үйл ажиллагааг сонгоно.

Үйлдэл хэсгээс **Бүлэг засах** сонголтыг сонгоно.



Бүлгийн мэдээлэлд засвар оруулан хадгалах товч дарна.



Эсвэл тухайн ангийн нэр дээр нь дарж ороход дараах 3 янзын таб харагдах бөгөөд үндсэн мэдээллийн хэсэгт бүлэг засах үйлдэл хийж засвар оруулах боломжтой.

Таб дах мэдээлэл	Тайлбар
Үндсэн мэдээлэл	Бүлгийн үндсэн мэдээллийг харуулна. Бүлгийн мэдээллийг өөрчилж хадгалсан бол засагдаж өөрчлөгдсөн хамгийн сүүлийн бүлгийн үндсэн мэдээллийг харуулна.
Суралцагч	Бүлэгт бүртгэлтэй суралцагчийн жагсаалтыг товч мэдээллээр хүснэгт хэлбэрээр харуулахаас гадна бүлэгт бүртгэлтэй суралцагчийг төлвөөр нь индикатораар харуулна.
Багш	Анги бүлэг удирдсан болон туслах багшийн

	мэдээллийг харуулна. Хэрэв анги удирдсан болон тухайн бүлгийн туслах багшийн мэдээллийг оруулаагүй бол бүлэг засах үйлдэл хийж анги удирдсан багшийн мэдээллийг оруулна.